



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/184

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.7, 15 дугаар зүйлийн 15.1, Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоол, Газрын даргын дэргэдэх Аргазүйн зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 4 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Салбарын хэмжээнд цаг агаарын урьдчилсан мэдээнд хэрэглэгдэх үг хэллэг, нэр томъёо нь ижил утгатай, ойлгомжтой байх, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэрэмжлүүлэх мэдээллийг нэгэн утгатайгаар, олон улсын стандартад нийцүүлэн зарлан мэдээлэх зорилгоор “Цаг агаарын урьдчилсан мэдээнд хэрэглэх үг хэллэг, нэр томъёоны тухай журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Хур тунадасны урьдчилсан мэдээ дүгнэх журам”-ыг 2 дугаар хавсралтаар, “Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах, сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээ гаргах, түгээх журам”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталж, 2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. “Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэрэмжлүүлэх систем”-ийг 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс улсын сүлжээнд нэвтрүүлж, ашигласугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Урьдчилан мэдээлэх хэлтсийн дарга Л.Оюунжаргал, аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/22 дугаар тушаалын 1 дүгээр заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ЭНХТҮВШИН

151190560

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
А/184 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт



Цаг агаарын урьдчилсан мэдээнд хэрэглэх үг хэллэг, нэр томъёоны тухай журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Журмын зорилго нь урьдчилан мэдээлэх салбараас гаргаж буй бүх төрлийн цаг агаарын урьдчилсан бичвэр мэдээнд хэрэглэгдэх үг хэллэг, нэр томъёо салбарын хэмжээнд нэгдсэн нэгэн ижил утга, агуулгатай, хэрэглэгчдэд ойлгомжтой, тодорхой байх зарчмыг хэрэгжүүлэхэд оршино.

Хоёр. Ерөнхий ойлголт

- 2.1. Цаг агаарын урьдчилсан мэдээ (УМ)-нд дараах цаг уурын хэмжигдэхүүнүүдийг зааж өгнө. Үүнд үлшил, хур тунадас, салхины хурд, чиглэл, агаарын хамгийн их бага температур (градус цельсээр), цаг агаарын үзэгдлүүд
- 2.2. Тусгай хэрэгцээний урьдчилсан мэдээнд дээр дурьдсанаас гадна хэрэглэгчдийн сонирхож буй цаг агаарын үзэгдэл, элементийг зааж өгч болно.
- 2.3. Цаг агаарын УМ-нд хэрэглэгчдэд аль болох ойлгомжтой, агаар мандлын үзэгдэл процессийн цаашдын хувьсал, өөрчлөлт, эрч хүч, цаг агаарын нөхцөл байдлын өөрчлөлтийг аль болох сайн тусгасан үг хэллэг, нэр томъёог хэрэглэнэ. Агаарын температурын болон салхины хурдны УМ-нд тухайн үзүүлэлтийн тоон утгыг зааж өгнө.
- 2.4. Урьдчилан сэргийлэх мэдээ (УСМ), сэрэмжлүүлэх мэдээ (СМ)-нд зөвхөн цаг агаарын аюултай (АҮ), болон гамшигт үзэгдэл (ГҮ)-ийн хэмжээнд хүрч байгаа цаг агаарын үзэгдэл, элементийг л зааж өгнө.
- 2.5. УСМ, СМ-нд дараахь зүйлсийг тусгана. Үүнд:
 - АҮ, ГҮ эхлэх сар, өдөр, цаг хугацааг /тодорхой мэдэгдэж байвал үдээс өмнө, хойно, шөнө дундаас өмнө, хойно г.м/, хэт богино хугацааны буюу 3-6 цагийн урьдчилалтай СМ, УСМ-нд АҮ, ГҮ эхлэх болон дуусах хугацааг цагаар зааж өгнө.
 - АҮ, ГҮ хамрах нутаг /аймаг, сум, хот суурингийн нэрс, зарим тохиолдолд газар зүйн нэр томъёо хэрэглэж болно /
 - АҮ, ГҮ -ийн нэр, түүний хамгийн их эрч хүчийг / тодорхой мэдэгдэж байвал АҮ, ГҮ-н үргэлжлэх хугацааг/ заана.

Гурав. Цаг хугацааны хувьд хэрэглэх үг хэллэг, нэр томъёо

- 3.1. Өнөө шөнө, маргааш, өнөөдөр, шөнөдөө, өдөртөө, өглөөгүүр, үдээс өмнө, үдээс хойш, оройдоо зэрэг доорх хүснэгтэд заасан үг хэллэг, нэр томъёог хэрэглэх ба сар, өдрийг тодорхой зааж бичнэ.

1 дүгээр хүснэгт. Хоногийг цагаар хуваасан үг хэллэгүүд

Нэр томъёо	Хугацаа /орон нутгийн цагаар/
Шөнөдөө	20:00-08:00
Өдөртөө	08:00-20:00
Үд дунд	11:00-15:00
Үдээс өмнө	09:00-12:00
Үдээс хойш	12:00-18:00
Оройдоо	18:00-22:00
Шөнө дундаас өмнө	21:00-01:00
Шөнө дунд	23:00-02:00
Шөнө дундаас хойш	02:00-05:00
Үүрээр	05:00-08:00
Өглөөгүүр	08:00-10:00

Дөрөв. Газар нутгийн хувьд хэрэглэх үг хэллэг, нэр томъёо

- 4.1.УМ-нд газар нутгийг засаг захиргааны нэгж болон газар зүйн (говийн бүс нутаг, уулархаг нутгаар гэх мэт) байрлалаар нь ялган бичнэ. Харин нэг өгүүлбэрт энэ хоёр ангиллын нэр томъёог хольж хэрэглэхийг хориглоно.
- 4.2.Цаг агаарын урьдчилсан мэдээнд бүс нутгийн хувьд хэрэглэх нэр томъёог 2 дугаар хүснэгтэд үзүүлснээр ойлгоно.

2.дугаар хүснэгт. Бүс нутгийн хувьд хэрэглэх нэр томъёоны тайлбар

	Бүсчлэл	Хамрагдах аймгууд
1.	Баруун аймгуудын нутаг	Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баянхонгор аймгийн нутаг
2.	Төвийн аймгуудын нутаг	Архангай, Хөвсгөл, Булган, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгийн нутаг
3.	Говийн аймгуудын нутаг	Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгийн нутаг
4.	Зүүн аймгуудын нутаг	Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутаг

- 4.3 Баруун, зүүн, төв, говийн аймгуудын нутгийн ихэнх, зүүн, баруун, хойд өмнөд хэсгээр, зарим газраар, эсвэл нутгийн зүүн хагаст, баруун хагаст, хойд хагаст, өмнөд хагаст зэрэг хэллэг, нэр томъёог хэрэглэнэ.
- 4.4 Аймгийн хувьд дээрх хэллэгт “аймгуудын” гэдгийг “сумдын” гэдэг үгээр орлуулан хэрэглэнэ. Мөн хотын хувьд “хэсгээр” гэдэг үг хэллэгийг хэрэглэж болно.
- 4.5.Хэрэв газар нутгийг дээрх байдлаар тодорхой ангилж, ялгах боломжгүй бол:
 - А.”ихэнх нутгаар эсвэл нутгийн ихэнх хэсгээр” (нутгийн 70%-д нь үзэгдэл ажиглагдахаар бол)
 - Б.”нутгийн зарим хэсгээр” буюу “зарим газраар” (нутгийн 30%-д нь үзэгдэл ажиглагдахаар бол) гэсэн нэр томъёог хэрэглэнэ.

Тайлбар: Температурын прогноз болон АҮ ба ГҮ-ийн УСМ, СМ-нд “зарим газраар”, “нутгийн ихэнх хэсгээр” гэдэг нэр томъёог хэрэглэхгүй.
- 4.6.Цаг агаарын УМ-нд хур тунадас, салхи үзэгдлийг “нутгийн ихэнх хэсэгт” буюу “нутгийн зарим хэсэгт” гэж заагаагүй бол тухайн үзэгдэл бүх нутгаар ажиглагдана гэж үзнэ.

Тав. Үүлшлийн урьдчилсан мэдээнд хэрэглэх үг хэллэг, нэр томъёо

5.1. Үүлшлийн УМ-нд хэрэглэх нэр, томъёо, тоон утгыг 3 дугаар хүснэгтэд үзүүлэв.

3. дугаар хүснэгт. Үүлшлийн хэмжээ, нэр томъёо

№	Нэр томъёо	Үүлний баллын хэмжээ
1.	Цэлмэг	Нийт үүлний (бүх мандлын үүл) 2 баллаас бага
2.	Багавтар үүлтэй	Дээд мандлын 1-8 баллын үүл, доод болон дунд мандлын 3 хүртэлх баллын үүл
3.	Солигдмол үүлтэй	1-3 баллаас 4-7 балл хүртлэх доод, дунд мандлын үүлтэй болж өөрчлөгдөх эсвэл 8 баллаас 3 балл хүртэл үүлтэй болж багасах зэрэг хагас хоногийн хугацаанд 2-оос дээш удаа өөрчлөгдөх бол
4.	Үүлэрхэг	Доод мандлын 8-10 балл, дунд мандлын сиймхийгүй 10 баллын нягт үүлтэй

Тайлбар: “Багавтар үүлтэй”, “цэлмэг” гэсэн нэр томъёонд бүх мандлын үүлийг, бусад нэр томъёонд доод болон дунд мандлын нягт үүлийг тооцно.

5.2. Хэрэв хагас хоногт үүлшлийн хэмжээ ихээхэн өөрчлөгдөж, тэр нь тухайн тохиолдолд цаг агаарын нөхцөл байдлыг тодорхойлохоор бол 2 дугаар хүснэгтэд заасны дагуу 2 өөр нэр томъёог хэрэглэж болно. Мөн “үүлшинэ”, “үүл багасна” гэсэн нэр томъёог хэрэглэж болно.

Жишээ нь: Өглөөгүүр багавтар үүлтэй, үдээс хойш үүлшинэ гэх мэт.

5.3. Өдөр, шөнө хоёрын үүлшлийн хэмжээ өөр өөр байхаар бол өөр нэр томъёо хэрэглэнэ.

Жишээ нь: Шөнөдөө үүлэрхэг, өдөртөө үүл багасна гэх мэт.

Зургаа. Хур тунадасны урьдчилсан мэдээнд хэрэглэх үг хэллэг, нэр томъёо

6.1. УМ болон АМ, СМ, УСМ-нд хур тунадас орох эсэхийг шөнө болон өдрөөр, нарийвчилбал хоногийн аль хугацаанд орохыг, мөн хэмжээ, эрч хүч, үргэлжлэх хугацааг зааж өгнө.

6.2. Хур тунадасны төлөв байдлыг “бороо”, “цас”, “хур тунадас” гэсэн нэр томъёог хэрэглэн заана. “Хур тунадас” гэсэн нэр томъёог хавар (4 дүгээр 1-нээс 5 дугаар сарын 15 хүртэлх хугацаанд), намар (9 дүгээр сарын 10-наас 10 дугаар сарын 10 хүртэлх хугацаанд)-ын шилжилтийн улиралд (цас бороо холилдож орох, цас орж байгаад бороо болох, бороо орж байгаад цас болох нөхцөлд) хэрэглэнэ. Мөн “хур тунадас” гэсэн нэр томъёоны оронд доорх хүснэгтэд заасан нэр томъёог хэрэглэж болох бөгөөд “хур тунадас, нойтон цас орно”, “хур тунадас, цас орно”, “бороо, хур тунадас орно” гэж нэр томъёог хамт хэрэглэхгүй.

4 дүгээр хүснэгт. Хур тунадасны нэр томъёо

Нэр томъёо	Тунадасны шинж, төлөв
Цастай бороо	Бороо, цас нэгэн зэрэг орох боловч их төлөв бороо зонхилж орох
Нойтон цас	Цас, бороо нэгэн зэрэг холилдон орох боловч их төлөв цас зонхилон орох
Бороо, нойтон цас	Эхлээд бороо орж байгаад нойтон цас болж орох
Цас, бороо	Эхлээд цас орж байгаад бороо болж орох

6.3. Дулааны улиралд орох хур тунадасыг фронтын гаралтай бол “бороо” конвекцын гаралтай бол “аадар бороо” гэсэн үндсэн нэр томъёог хэрэглэнэ.

Фронтын болон конвекцын хур тунадас хавсран ажиглагдах үед “аадар бороо” гэсэн нэр томъёог хэрэглэнэ.

- 6.4 . Хур тунадасны үргэлжлэх хугацааг заахдаа “үе,үе” /2 ба түүнээс олон удаа тасалдаж орох үед/, “түр зуур” /хагас хоногт 3 цагаас богино/, “үргэлжлэн орох” /3-12 цаг үргэлжлэх/, “зүсэрч орно” /12 цагаас дээш хугацаагаар үргэлжлэх/ гэсэн нэр томъёог дараах хүснэгтэд заасан нэр томъёонд нэмэлт болгон хэрэглэж болно.
- 6.5 Хур тунадасны хэмжээний хувьд 5, 6 дугаар хүснэгтэд заасан хэмжээг илэрхийлэх үг хэллэг, нэр томъёог хэрэглэнэ.

5 дугаар хүснэгт. Шингэн болон холимог хур тунадасны урьдчилсан мэдээнд хэрэглэх хэллэг, нэр томъёо

Үзэгдэл, үг хэллэг, нэр томъёо	Хур тунадасны хэмжээ, мм/12ц	хугацаа
Бороо		
• Бага зэргийн бороо	=<1.4	
• Бороо	1.5-29.9	
• Их бороо	30.0-49.9	
• Их усархаг бороо	>=50.0	
Аадар бороо		
• Бага зэргийн аадар	=<1.4	3 цагаас бага
• Аадар бороо	1.5-29.9	3 цагаас бага
• Усархаг аадар бороо	>=30.0	3 цагаас бага
• Усархаг ширүүн аадар бороо	>=30.0	1 цагаас бага
Хур тунадас		
• Ялимгүй хур тунадас	=<1.4	
• Хур тунадас	1.5-29.9	
• Их хур тунадас	30.0-49.9	
• Аадар их хур тунадас	>=50.0	

Тайлбар: Аадар борооны хувьд аянга цахилгаан ажиглагдах бол аянга цахилгаантай бага зэргийн аадар орно гэх мэт хэрэглэнэ.

6 дугаар хүснэгт. Хатуу хур тунадасны урьдчилсан мэдээнд хэрэглэх хэллэг, нэр томъёо

Нэр томъёо	Хур тунадасны хэмжээ, мм/12ц	Тайлбар
Ялимгүй цас орно, цас бударна, хялмаална	=<0.1	
Цас	0.2-4.9	
Их цас, нойтон цас	5.0-9.9	Аюултай үзэгдэл
Аадар их цас, нойтон цас	>=10.0	Гамшигт үзэгдэл

- 6.6. Хэрэв урьдчилсан мэдээнд “цэлмэг” гэсэн бол “Хур тунадас /бороо, цас/ орохгүй” гэж бичихгүй байж болно.
- 6.7. Бүс нутаг, аймгийн нутгаар тунадасны урьдчилсан мэдээ гаргахад зарим газраар их бороо орох нөхцөл бүрдээд АҮ ажиглагдахаар бол өдөртөө /шөнөдөө/ “бороо”, зарим газраар “их бороо” орно гэж бичиж болно. “Ихэнх нутаг”, “зарим газраар” гэсэн нэр томъёог нэг зэрэг хэрэглэж болохгүй. “Их бороо”, “Их цас” орох нөхцөл бүрдвэл СМ бичнэ.

6.8. Эдгээр үзэгдлийн код болон тэмдэглэгээг өдөр шөнөөр ялгах ба 8 дугаар хүснэгтэд зааснаар хэрэглэнэ.

Долоо. Цаг агаарын үзэгдлийн урьдчилсан мэдээнд хэрэглэх үг хэллэг, нэр томъёо

- 7.1.Цаг агаарын УМ-нд хур тунадаснаас гадна цасан болон шороон шуурга, явган шуурга, манан, мөстөлт, нөөлөг, мөндөр, цан, шавсан нойтон цас мөн түүнчлэн дуу цахилгаан зэрэг цаг агаарын үзэгдлийг заана.
- 7.2.Цаг агаарын УМ болон АМ, СМ, УСМ-нд үзэгдлийн эрч хүчний хувьд “хүчтэй (их, усархаг)”, “онц хүчтэй (маш их хэмжээний, маш их усархаг)” гэсэн нэр томъёог хэрэглэнэ. Харин “зөөлөн” гэсэн нэр томъёог тухайн үзэгдэл, элементийн хэмжээ, эрч хүч, үргэлжлэх хугацаа нь АҮ-ийн хэмжээнд хүрэхээргүй бол УМ-нд хэрэглэнэ.Салхины хурдны хэмжээг 7 дугаар хүснэгтэд үзүүлэв.

7 дугаар хүснэгт. Салхины хурд, эрч хүч

Салхины хурд (м/с)	Нэр томъёо
0 – 5	Зөөлөн
6 – 14	Дунд зэргийн
15 – 24	Хүчтэй
25 – 32	Онц хүчтэй
>33	Догшин

Найм. Салхины урьдчилсан мэдээнд хэрэглэх үг хэллэг, нэр томъёо

- 8.1 Цаг агаарын урьдчилсан ба СМ, УСМ-нд салхины чиглэл, хурдыг заана.
- 8.2. Салхины чиглэлийг 4 зүг, 4 зовхисоор (хаанаас салхилж байгаагаар нь) заах ба чиглэл гэдэг үгийг бичихгүй.
- 8.3. Хэрэв хагас хоногт салхины зүг, хурд өөрчлөгдөх бол хугацааг зааж, “багасна” эсвэл “ширүүснэ” гэсэн хэллэг, нэр томъёог хэрэглэнэ.
Жишээ нь, салхи үдээс өмнө баруун өмнөөс 3-8 м/с, үдээс хойш баруун хойш эргэж 20 м/с хүрч ширүүснэ.
- 8.4 .Цаг агаарын УМ-нд салхины зонхилох ба хамгийн их өрөвхийлэлтийн хурдыг заана. СМ,УСМ-нд салхины зөвхөн хамгийн их ба өрөвхийлэлтийн хурдыг заана.
- 8.5 .Цаг агаарын УМ-нд салхины зонхилох хурдыг 5 м/с-ээс ихгүйгээр, хамгийн их өрөвхийлэлтийн хурдыг 2 м/с-ээс ихгүй зайцтай бичих ба зонхилох хурдны захын утгаас өрөвхийлэлтийн утга нь 2 м/с ба түүнээс их байна. Жишээ нь: 5-10 м/с, зарим үед 12-14 м/с хүрч ширүүснэ г.м. Харин нэг зайцад ердийн ба аюултай, онц аюултай үзэгдлийн хязгаарыг дамнуулан бичиж болохгүй. Жишээ нь: салхи 15-17 м/с юмуу 27-29 м/с гэж бичиж болохгүй.
Тайлбар: Салхины хамгийн их өрөвхийлэлтийн хурдыг ганц утгаар “хүрч” гэж бичиж болно. Жишээ нь: Салхи 17-22 м/с, үдээс хойш 40 м/с хүрч ширүүснэ.

- 8.6 УМ-нд салхины хурдыг зөөлөн, сэвэлзүүр салхитай гэж бичиж болно. Хэрэв УМ-нд салхины ширүүсэл өгвөл зүгийг нь заавал зааж, зөөлөн, сэргчигнүүр салхитай гэж өгөх шаардлагагүй.
- 8.7 . Цаг уурын автомат станцын ажиглалтаар салхины өрөвхий их хурдыг сайн хэмждэг болсон тул “түр зуур”, “дуу цахилгааны үед”, “нөөлөг салхи” “секундэд метр хүрч ширүүснэ” гэж салхины хурдыг аль болох тоон утгаар зааж өгөх хэрэгтэй. Салхины агшин зуурын хурдыг бичихдээ түр зуур гэдэг үгийг секундэд гэдэг үгний өмнө бичнэ.

Ес. Цаг агаарын УМ ба АМ,СМ,УСМ-нд АҮ, ГҮ-ийн эхлэх, төгсөх, хугацаа, эрч хүчний өөрчлөлт, хамрах нутгийг заахдаа хэрэглэх үг хэллэг, нэр томъёо

- 9.1 Хэрэв АҮ ба ГҮ-ийн эхлэх, зогсох, эрч хүч нь мэдээ зохиосноос хойш 6 цагийн дотор өөрчлөгдөхөөр бол түүний хугацааг 3 цагаас ихгүй зайцаар зааж, харин эрч хүч нь мэдээ зохиосноос хойш 1-2 цагийн дотор өөрчлөгдөхөөр бол “ойрын нэг цагт”, эсвэл “ойрын 2 цагт “ гэсэн нэр томъёог сэрэмжлүүлэх мэдээнд хэрэглэнэ.
- 9.2. Хэрэв АҮ, ГҮ-нь мэдээ зохиож байгаа хугацаанаас 6 цагаас дээш цагийн хойно үүсэх буюу зогсохоор бол 1 дүгээр хүснэгтэнд заасан нэр томъёог хэрэглэнэ.
- 9.3. Хоногийн цаг агаарын УМ ба АМ, СМ, УСМ-нд 1 дүгээр хүснэгтэд заасан нэр томъёог хэрэглэх боломжгүй бол “шөнөдөө”, “өдөртөө “ гэдэг нэр томъёог хэрэглэнэ.
- 9.4.Хэрэв тухайн үзэгдэл /хур тунадас/ үүсэх эсэхэд /орох, орохгүй/ итгэл төгс биш байгаа тохиолдолд нийтийн хэрэгцээний цаг агаарын УМ-г хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх, радио, телевизээр нэвтрүүлэхэд “боломжтой”, “боломж бага” гэсэн нэр томъёог хэрэглэж болно. Харин хэрэглэгч байгууллагад өгч байгаа цаг агаарын УМ ба АМ, СМ, УСМ-нд дээрх нэр томъёог хэрэглэхийг хориглоно.
- 9.5.Тухайн сум, аймаг, бүс нутгийн хэмжээнд СМ, УСМ өгсөн бол тухайн харгалзах хугацааны урьдчилсан мэдээнд үзэгдэл, хязгаар утгыг холбогдох хэллэг, нэр томъёог хэрэглэн тусгаж өгнө.

Арав. Агаарын температурын урьдчилсан мэдээнд хэрэглэх үг хэллэг, нэр томъёо





- 10.1 УМ-нд агаарын температурын шөнийн хамгийн бага, өдрийн хамгийн их утгыг заана.
- 10.2 Агаарын температурыг хот суурингийн УМ-нд 2 градусын зайцтайгаар эсвэл 1 утгаар, бүс нутгийн УМ-нд 5 градусын зайцтайгаар зааж өгнө.
- 10.3 Агаарын температур 5 градус ба түүнээс илүү гаж / хагас хоногийн огцом өөрчлөлтийг/ явцтай үед температурын өөрчлөлтийг зөвхөн хоногийн ба хагас хоногийн нарийвчилсан мэдээнд заана.
- 10.4 Хэрэв температур гаж явцтай байхаар бол өглөөгүүр /өдөр, орой/ ажиглагдах түүний хамгийн их /бага/ утгыг заана. Температурын гаж явцыг заахдаа “дулаарч”, “хүйтэрч”, “сэрүүсч”, “хүйтний эрч суларч” гэдэг нэр томъёог хэрэглэнэ.

Жишээ нь: оройдоо 11 градус хүйтэн, шөнөдөө хүйтний эрч суларч өглөөгүүр 5 градус хүйтэн. Өглөөгүүр 10 градус, өдөртөө хүйтэрч оройдоо 18 градус хүйтэн гэх мэт.


- 10.5 Хэрэв агаарын хамгийн их, бага температурын хоног хоорондын өөрчлөлт нь 20 градус буюу түүнээс ихээр хүйтрэх бол “эрс хүйтэрнэ” гэдэг нэр томъёог хэрэглэнэ.
- 10.6 Ургамлын ургалтын үед агаарын болон хөрсний гадаргын температур 0 градусаас буурч хүйтрэхээр бол “цочир хүйтрэнэ” гэдэг нэр томъёог хэрэглэнэ.
- 10.7 Хэрэв тухайн хот суурин, нутагт агаарын температур үнэмлэхүй бага /өвөл/, үнэмлэхүй их /зун/ температурт ЦУОШГ-ын даргын 2015 оны А155 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад заасан нөхцөл бүрдэхээр бол “үргэлжилсэн их халуун”, “их хүйтэн” гэдэг нэр томъёог хэрэглэнэ.

8. дугаар хүснэгт. Үзэгдлийн нэр томъёо, код болон тэмдэглээ (өдөр, шөнөөр)

ҮЗЭГДЭЛ	КОД	ШӨНӨ	ӨДӨР
БОРОО			
Бага зэргийн бороо	60		
Бороо	61		
Их бороо	63		
Их усархаг бороо	68		
ААДАР БОРОО			
Бага зэргийн аадар	80, 81		
Аянга цахилгаантай бага зэргийн аадар бороо	90, 91		
Аадар бороо	82, 83		
Аянга цахилгаантай аадар бороо	92, 93		
Усархаг аадар бороо	84, 85		

Аянга цахилгаантай усархаг аадар бороо	94, 95		
Усархаг ширүүн аадар бороо	86, 87		
Аянга цахилгаантай усархаг аадар бороо	96, 97		
ЦАС			
Ялимгүй цас	23, 24		
Цас	71		
Их цас, Нойтон цас	73		
Аадар их цас, Нойтон цас	75		
ХҮР ТУНАДАС			
Ялимгүй хур тунадас	27, 28		
Хур тунадас	65		
Их хур тунадас	66		
Аадар их хур тунадас	67		

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
А/184 дүгээр тушаалын 2 дугаар хэвсрэлт



Хур тунадасны урьдчилсан мэдээ дүгнэх журам

Хур тунадасны урьдчилсан мэдээний таарцыг 1,2 дугаар хүснэгтийн дагуу дүгнэнэ.

1 дүгээр хүснэгт. Шингэн болон холимог тунадасны урьдчилсан мэдээний таарц

Мэдээнд хэрэглэсэн хэллэг, нэр томъёо	12/1 цагт орсон хур тунадасны хэмжээ, /мм/				
	Ороогүй	0.0-1.4	1.5-29.0	30.0-49.0	≥50
Бороо орохгүй, Хур тунадасгүй	100	0	0	0	0
Бага зэргийн бороо /60/ бага зэргийн аадар /80,81/ дуу цахилгаантай бага зэргийн аадар /90,91/, ялимгүй хур тунадас /27,28/	0	100	50	0	0
Бороо /61/, аадар бороо /82,83/, дуу цахилгаантай аадар бороо /92,93/, хур тунадас /65/	0	50	100	50	0
Их бороо /62/ усархаг аадар бороо /84,85/, дуу цахилгаантай усархаг аадар бороо /94,95/ Их хур тунадас, нойтон цас /66/	0	0	50	100	50
Их усархаг бороо /63/ Усархаг ширүүн аадар бороо /86,87/ Дуу цахилгаантай усархаг ширүүн аадар бороо /96,97/ Аадар их хур тунадас /67/	0	0	0	50	100

Тайлбар: Дуу цахилгаантай бага зэргийн аадар орно гэж өгсөн үед ажиглалтын хугацаанд 16,17-гоор, ажиглалтын хугацааны хооронд 9-өөр коодлогдох үзэгдэл ажиглагдсан тохиолдолд 50% гэж авна. Аадар бороо / дуу цахилгаантай аадар бороо орно гэж өгсөн үед хэмжээний хувьд таарсан ч, 4 цагаас илүү хугацаагаар үргэлжилсэн үед 75% гэж дүгнэнэ.

Бороо /хур тунадас/ орохгүй гэж өгсөн үед 0.0мм бороо /хур тунадас/ орсон бол таарцыг 100.0% гэж дүгнэнэ.

2 дугаар хүснэгт. Хатуу тунадасны урьдчилсан мэдээний таарц

Мэдээнд хэрэглэсэн хэллэг, нэр томъёо	12 цагт орсон хур тунадасны хэмжээ, / мм /				
	Ороогүй	0.0-0.1	0.2-4.0	5.0-9.0	≥10
Цас орохгүй	100	50	0	0	0
Ялимгүй цас /23,24/	50	100	50	0	0
Цас /71/	0	50	100	50	0
Их цас орно /73/	0	0	50	100	50
Аадар их цас орно /75/	0	0	0	50	100

Тайлбар.Цан, хяруунаас тунадас хэмжсэн тохиолдлыг тунадас орсон гэж тооцохгүй.

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
А/184 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт



**Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах,
сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээ гаргах, түгээх журам**

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Нийтийн хэрэгцээнд зориулан цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах мэдээ (АМ), сэрэмжлүүлэх мэдээ (СМ), болон урьдчилан сэргийлэх мэдээ (УСМ) гаргахад энэхүү журмыг иш үндэс болгоно.
- 1.2. Монгол улсын засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын дагуу хөдөө аж ахуй болон нийгэм эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулж болзошгүй ус, цаг агаарын үзэгдлийг эрч хүч, хамрах газар нутаг, үргэлжлэх хугацаа зэргээс хамааруулан цаг агаарын аюултай үзэгдэл (АҮ), гамшигт үзэгдэл (ГҮ) гэж ангилна.
- 1.3. ГҮ, АҮ ажиглагдах нөхцөл бүрдсэн тохиолдолд урьдчилан мэдээлэх салбарууд харгалзан уг үзэгдлээс УСМ, СМ гаргана. Нийтийн хэрэгцээнд зориулж гаргах ус цаг агаарын гамшигт үзэгдлээс УСМ, СМ-нд Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтанд заасан нөхцлийг тусгана. Харин тусгай хэрэгцээний мэдээнд тухайн хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагаар, хамтарч ажиллах хоёр талын гэрээнд тусгасны дагуу заасан нөхцлөөр ГҮ-ээс УСМ, АҮ-ээс СМ гаргана.
- 1.4. Урьдчилсан мэдээнд цаг агаарын байдал эрс өөрчлөгдөх боловч эрч хүч, үргэлжлэх хугацаа, хамрах газар нутаг нь Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтанд заасан АҮ-ийн хэмжээнд хүрэхгүй, эсвэл 2-3 хоногийн дараа цаг агаар эрс өөрчлөгдөж цаашид АҮ-ийн хэмжээнд хүрч болзошгүй гэж үзсэн тохиолдолд эдийн засгийн чухам ямар салбарт илүү нөлөөлөхөөс нь хамааруулан малчид, тариаланчид, тээвэрчид, иргэдэд урьдчилан анхааруулах мэдээ (АМ)-г ЦУОШГ-ын даргын 2015 оны А155 тоот тушаалын 2 дугаар хавсралтын дагуу гаргаж мэдээлнэ.
- 1.5. АМ, СМ, УСМ-нд уг үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга замыг тусгасан зөвлөмжийг өгч болно.
- 1.6. Үйлдвэр үйлчилгээ олонтой, хүн ам төвлөрсөн улсын нийслэл, томоохон хот суурин, аймгийн төвөөр тусад нь АМ, СМ, УСМ гаргаж болно.
- 1.7. Төв, орон нутгийн урьдчилан мэдээлэх салбарууд СМ, УСМ-г 12-24 цагийн өмнөөс, АҮ, ГҮ болох нөхцөл тодорхой бол 48-72 цагийн өмнөөс зохиож гаргана.
- 1.8. СМ, УСМ-г заасан хугацаанд гаргаагүй үед АҮ, ГҮ болох нөхцөл бүрдсэн тохиолдолд цаашид үргэлжлэх хугацаа, хамгийн их эрч хүч, хамрах газар нутгийг заасан СМ, УСМ зохиож холбогдох мэдээллийн хэрэгслээр тухай бүр нь шуурхай дамжуулах арга хэмжээ авна. Гэсэн хэдий ч хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учирсан бол АҮ, ГҮ-г мэдээлж чадаагүй гэж үзнэ.
- 1.9. Төвөөс нийтийн хэрэгцээнд зориулж гаргах СМ, УСМ -ний хамрах нутаг дэвсгэрийн нэгж нь аймаг байна. АМ, СМ, УСМ-нд тухайн үеийн аэросиноптик нөхцөл, цаг агаарын байдал болон газар нутгийн онцлог

i:\2019\al\0627-184.docx

зэргээс шалтгаалан аймгийн нутгаар, эсвэл аймгийн нутаг дэвсгэрийг хэсэгчлэх, боломжтой бол сумдыг нэр зааж өгч болно.

1.10 Орон нутгийн салбараас нийтийн хэрэгцээнд зориулж гаргах АМ, СМ, УСМ-ний хамрах нутаг дэвсгэрийн нэгж нь сум байх ба тухайн үеийн аэросиноптик нөхцөл, цаг агаарын байдлаас шалтгаалан аймгийн нутгаар бүхэлд нь өгч болно.

1.11 УСМ, СМ-ний бичлэгт дараахь зүйлсийг тусгана. Үүнд:

- АҮ, ГҮ эхлэх сар, өдөр, цаг хугацааг /боломжтой бол үдээс өмнө, хойно, шөнө дундаас өмнө, хойно г.м/, хэт богино хугацааны СМ, УСМ-нд АҮ, ГҮ эхлэх болон дуусах хугацааг цагаар зааж өгнө.
- АҮ, ГҮ хамрах нутаг /аймаг, сум, хот суурингийн нэр/
- АҮ, ГҮ - ийн нэр, түүний хамгийн их эрч хүчийг /боломжтой бол АҮ, ГҮ-н үргэлжлэх хугацааг/ заана.

1.12 Цаг агаарын УМ-нд ГҮ-ийг тусгасан бол УМ-ний бичвэрийн өмнө “Харанга!!!, Цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ”, АҮ-ийг тусгасан бол “Дохио !, Цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ”, ус цаг агаарын эрс өөрчлөлтийг тусгасан бол ямар салбарт илүү нөлөөлөхөөс нь хамааруулан “Малчид, тариаланчид, тээвэрчид, иргэдийн анхааралд” гэж бичнэ.

1.13 Урьдчилсан мэдээний үйлчлэх хугацаанд нутгийн аль нэг хэсэгт АҮ, нөгөө хэсэгт ГҮ, мөн цаг агаар эрчимтэй муудах, цаашид АҮ-ийн хэмжээнд хүрч болзошгүй нөхцөл бүрдвэл УСМ, СМ, АМ гэсэн дарааллаар мэдээг бичнэ.

1.14 СМ болон УСМ-нд цаг хугацаа, эрч хүч, газар нутгийн хувьд хагас хоног, 3-6 цагаар нарийвчлалт хийнэ.

1.15 АҮ эсвэл ГҮ нь 6 цаг ба түүнээс их хугацаагаар завсарлаад дахин үүсэх үед, эсвэл эрч хүч нь 6 цаг ба түүнээс их хугацаагаар сулраад дахин эрчимшвэл шинээр АҮ, ГҮ үүслээ гэж үзэж СМ, УСМ зохионо.

1.16 АМ, СМ, УСМ-ийг төв, орон нутгийн хэмжээнд веб-д суурилсан Цаг агаарын урьдчилан сэрэмжлүүлэх систем (ЦАУСС) (<http://alarm.tsag-agaar.gov.mn/>)-ийг ашиглан нэгдсэн байдлаар гаргана.

1.17 Орон нутаг ЦАУСС ашиглан АМ, СМ, УСМ-ний саналыг 13:00 цагт бүрэн оруулсан байна. ЦАУСС-д оруулсан сумаар гаргасан АМ, СМ, УСМ мэдээнд тулгуурлан бичвэр мэдээллийг технологийн дагуу боловсруулж УМХ-н шуурхай мэдээллийн сангийн серверт 14:30 цагаас өмнө байршуулна.

1.18 Орон нутгийн салбаруудын 13:00 цагт ирүүлсэн саналыг дүгнэж, ажил дүгнэх үзүүлэлтэнд нь оруулан тооцно.

1.19 Төвийн тухайн өдрийн ээлжийн технологич инженер орон нутгаас оруулсан АМ, СМ, УСМ-г хянаж, нэгтгэн, эцсийн шийдвэрийг 15:00 цагт ЦАУСС-р олон нийтэд хүргэх ба тухайн ээлж уг нэгтгэн гаргасан мэдээний таарцыг дүгнэж, ажлын үзүүлэлт болгож авна.

1.20 УСМ, СМ-ний эцсийн үр дүн, хариуцлагыг тухайн өдрийн төв, орон нутгийн синоптик инженер, шуурхай мэдээллийн ээлж тус тус хариуцна.

Хоёр. Урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, анхааруулах мэдээ гаргахад ашиглах нэмэлт материалууд, тооцоо

2.1 УСМ, СМ, АМ гаргахдаа цаг агаарын УМ гаргахад ашигладаг бүх зураг, материалыг ашиглаж, тооцоог хийхээс гадна дараах зураг, мэдээ, материалыг харж ашиглаж, дүн шинжилгээ, тооцоо хийсэн байна. Үүнд:

а. Цаг агаарын бодит болон прогноз зургууд

- Хиймэл дагуул олон сувгийн зургууд
- Радарын зургууд (радарын холын алслалтанд хамрагдаж болох аймгууд)

- Фронтын шилжилт, хувьсалд дүн шинжилгээ хийж фронтын төрөл, шилжилтийн хурд, эрчмийг үнэлж, 36-48 цагийн прогноз зураг дээр фронт зурах.
- Цаг агаарын аюултай үзэгдлийн 144 цаг хүртлэх прогноз зургууд
- Дотоодын тоон прогнозын загваруудын 144 цаг хүртлэх прогнозад салхи, температур, тунадасны тодорхой критери утгуудыг тооцоолсон байдал

б. Цаг агаарын бодит мэдээллүүд

- Цаг уурын автомат станцуудын мэдээ
- Цаг агаарын аюултай үзэгдлийн бодит болон өнгөрсөн хугацааны мэдээ, зураг
- Цаг агаарын аюултай үзэгдлийн бүртгэлээс төсөөтэй тохиолдол олж, тухайн тохиолдолын холбогдох мэдээ, мэдээлэл, зураг, материал

в. Бусад нэмэлт тооцоо

- Хүчтэй салхи, цасан болон шуурга, их цас, бороо орох гэх мэт аюултай үзэгдэл ажиглагдах аэросиноптикийн нөхцлийн тохироо, босго утгуудуудын шинжүүрүүдийг хангасан байдал

Дөрөв. Мэдээний төсөл боловсруулах, хэлэлцэх, эцэслэн гаргах

- 4.1 УСМ, СМ, АМ-г гаргахын тулд ээлжийн инженер, ахлах инженер эсвэл технологич инженер хамтран тухайн хугацаанд бэлэн байгаа 2.1-д заасан мэдээллүүд, нэмэлт тооцоонуудыг ашиглан, дүн шинжилгээ хийж, УСМ, СМ, АМ-ний төслийг боловсруулна.
- 4.2 Өдөр бүр 10:30 цагаас тухайн өдрийн цаг агаарын урьдчилсан мэдээний онцлог, ажиглагдаж болох АҮ, ГҮ-ийн синоптик процесс, арга загваруудын тооцоолсон байдал түүнд өгсөн үнэлэлт, дүгнэлтийн талаар төвийн тухайн өдрийн ээлжийн технологич инженер тухайн өдрийн төв, орон нутгийн инженерүүдэд санал, зөвлөгөө өгнө. Орон нутгаас санал авч хэлэлцэнэ. Хэлэлцүүлэгт төв, орон нутгийн ээлжийн синоптик инженерүүд бүгд оролцоно.
- 4.2 Цаг агаарын АҮ, ГҮ ажиглагдах нөхцөл бүрдсэн үед төв, орон нутагт УМ, АМ, СМ, УСМ-ний төслийн нарийвчилсан нэгдсэн хэлэлцүүлэгийг 13:00 цагаас хийнэ. Хэлэлцүүлэгийг УМХ-ийн дарга, даргын эзгүйд төвийн ээлжийн технологич инженер удирдан явуулна. Хэлэлцүүлэгийн удирдагчийн санаачлагаар бусад салбарын инженерүүд, эрдэм шинжилгээний ажилтнууд гэх мэт шаардлагатай хүмүүсийг зөвлөх эрхтэйгээр урьж оролцуулж болно. Бусад үед нарийвчилсан хэлэлцүүлэгийг төв, орон нутагтаа тус, тусдаа хийнэ.
- 4.3 Хэлэлцүүлгийн үед шаардлагатай зураг, мэдээллийг тусгай самбар, дэлгэц дээр харуулсан байна.
- 4.4 Хэлэлцүүлгийн илтгэгч нь:
- Даралтын орон, фронтын системд сүүлийн 1-2 хоногт гарсан өөрчлөлт, ялангуяа манай улсын цаг агаарын байдлыг нөхцөлдүүлэгч даралтын орон, фронтын систем, үүшлийн орны шилжилт, хувьсал
 - Тухайн үеийн цаг агаарын байдал,
 - Тоон прогноз, нэмэлт тооцоо, тооцооны аргуудын үр дүн, өөрийн орон нутгийн онцлог тэдгээрт хийсэн өөрийн үнэлэлт, дүгнэлт
 - АМ, СМ, УСМ-ний төслөө товч тодорхой танилцуулна.
- 4.5 Бусад илтгэгчид
- Орон нутаг хариуцсан технологич инженер, түүний эзгүйд ээлжийн 4-р инженер орон нутгийн АМ, СМ, УСМ-ний саналыг нэгтгэж танилцуулна.

- АМ, СМ, УСМ-ний төслийн талаар зөрөөтэй санал ирүүлсэн орон нутаг санал болон өөрийн орон нутгийн онцлог, тоон прогноз, нэмэлт тооцоо, тооцооны аргуудын үр дүнгийн орон нутаг дах онцлог тэдгээрт хийсэн өөрийн үнэлэлт, дүгнэлтийг товч тодорхой танилцуулна.
- 4.6 Төвийн тухайн өдрийн ээлжийн инженер төв, орон нутгийн АМ, СМ, УСМ-ний саналыг нэгтгэж дүн шинжилгээ хийж, урьдчилсан мэдээний төсөл хэлэлцэхэд оролцсон олонхийн саналыг баримтлан ээлжийн технологич инженертэй хамтран эцэслэн шийдвэрлэнэ.
- 4.7 Ажлын бус үед шинээр сэрэмжлүүлэх болон урьдчилсан сэргийлэх мэдээ зохиох эсэхийг ээлжийн инженер бие даан шийдвэрлэнэ. Шаардлагатай гэж үзвэл синоптикийн ээлжийн инженер **онцгой үед ажиллах журмын** дагуу арга хэмжээ авна.
- 4.9 Урьдчилсан мэдээ зохиох үед ээлжийн инженер СМ болон УСМ-ний төсөл оруулж хэлэлцүүлээгүй боловч мэдээ зохиоход оролцож буй хүмүүсээс хэн нэг нь сэрэмжлүүлэх болон урьдчилан сэргийлэх мэдээ зохиох санал гаргавал уг саналыг авч хэлэлцэнэ.
- 4.10 Цаг агаарын ГҮ ажиглагдах нөхцөл бүрдсэн гэж үзсэн үед ГҮ-ээс урьдчилан сэргийлэх мэдээний төслийг хэлэлцүүлэхэд доор дурьдсан хүмүүсийг боломжтой бол урьж оролцуулах шаардлагатай: ЦУОШГ-ын дарга, мэдээлэл үйлчилгээний хариуцсан мэргэжилтэнүүд, УЦУОСМХ-ийн захирал, эрдэм шинжилгээний ажилчид.
- 4.11 Ажлын бус цагаар цаг агаарын ГҮ ажиглагдах нөхцөл бүрднэ гэж үзсэн үед орон нутагт УЦОШТ-ийн дарга, мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга, ерөнхий технологич инженер, ХАА, Цаг уурын инженер гэх мэт холбогдох хүмүүсийг ГҮ-ээс урьдчилан сэргийлэх мэдээний төслийг хэлэлцүүлэгт оруулах шаардлагатай.

Тав. Олон нийтэд хүргэх

- 5.1 АҮ-ээс сэрэмжлүүлэх, ГҮ-ээс урьдчилан сэргийлэх мэдээг ээлжийн технологич инженер хянасны дараа хүчин төгөлдөр болох ба веб болон бичиглэл хэлбэрээр боловсруулан, радио, телевиз, интернэт, сонин хэвлэл, олон нийтийн сүлжээгээр хэрэглэгчдэд хүргэнэ.
- 5.2 УСМ, СМ-ийг Төр засгийн удирдлагууд, гамшгийн удирдлагыг хэрэгжүүлдэг байгууллагуудад зарлан мэдээлэх систем, факс, цахим шуудан, албан бичгээр шуурхай хүргэнэ.
- 5.3 АМ, СМ, УСМ-г олон нийтэд хүргэхдээ өнгөний коод ашиглана. АМ-г шар өнгөөр, СМ-г улбар шар өнгөөр, УСМ-г улаан өнгөөр илэрхийлнэ. Тухайлбал: Шар, улбар шар, улаан өнгийн дэвсгэр дээр эсвэл харгалзах өнгийн үсгээр бичнэ.
- 5.4 Төвд зөвхөн УСМ гаргасан үед болон гэнэтийн уруйн үер болох нөхцөл бүрдсэн үед багц мессежийн систем ашиглан төр, засгийн удирдлагууд, холбогдох газар, агенлагийн дарга, гэрээт байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагуудад шуурхай хүргэнэ.
- 5.5 Олон нийтийн радио, телевиз нь Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолын хавсралтад тусгагдсан Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журмын 3.1.3, Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6-д заасны дагуу цаг агаарын ГҮ-ээс УСМ-г “Харанга” дохиотойгоор “Цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ” гэсэн толгойтойгоор, СМ-г “Дохио !, Цаг агаарын аюултай үзэгдлээ сэрэмжлүүлэх мэдээ” гэсэн толгойтойгоор 4 дүгээр хавсралтад заасан хуваарийн дагуу, шаардлагатай үед 15 минутын дотор тухайн үеийн нэвтрүүлгийн дундуур оруулан зарлана.

- 5.6 Ээлжийн инженерүүд болон Интернетэд суурилсан студийн холбогдох ажилтан мэдээ зарлалтын цаг хугацаа, хэллэг найрлаганд хяналт тавина.
- 5.7 Орон нутаг СМ, УСМ-г харъяа аймгийн удирдлагууд, онцгой байдлын ерөнхий газрын орон нутгийн салбар болон холбогдох байгууллагуудад шуурхай хүргэх арга хэмжээ авна. Иргэдэд багц мессежийн системээр хүргэх үйл ажиллагааг явуулна.
- 5.8 Олон нийтэд өөрийн цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр шуурхай хүргэх, УСМ гаргасан үед хэвлэлийн бага хурал зохион байгуулах, хэвлэл мэдээллийн байгууллагуудад шуурхай мэдээллэх үүргийг Интернетэд суурилсан студийн хэсэг хариуцах ба шаардлагатай үед ажлын бус цагаар ажиллана.
- 5.9 Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл болсон талаарх мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэнэ.
- 5.10 5.2 зааснаас бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ч ГҮ-ээс УСМ-г “Харанга” дохиотойгоор зарлан мэдээлнэ.
- 5.11 Дулааны бурганы гаралтай АҮ, ГҮ-ийг аль болох эртнээс, хэдэн цагаас хэдэн минутын өмнөөс илрүүлж, УСМ,СМ-ийг гаргаж хэрэглэгчдэд шуурхай хүргэнэ.